

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Үйлдвэржилт хөгжлийн корпорац ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/004/НА-СТА-ОНӨҮГ

|                                                                                              |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
|----------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Баянхонгор хот<br>2025.03.15 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a><br>Аудитын менежер: М.Алтантуяа<br>Утас: 99061829 Цахим хаяг: <a href="mailto:altantuyam@audit.gov.mn">altantuyam@audit.gov.mn</a><br>Аудитор: А.Адилзаяа<br>Утас: 80870886 Цахим хаяг: <a href="mailto:adilzayaa@audit.gov.mn">adilzayaa@audit.gov.mn</a><br>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> |
|----------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

|                                                                                                                 |    |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....                                                                            | 3  |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....                                                                          | 6  |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....                                                                        | 11 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН .....                                                                                         | 14 |
| 4.1 Ерөнхий зүйл .....                                                                                          | 14 |
| 4.2 Материаллаг байдал .....                                                                                    | 14 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....                                                             | 15 |
| Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно ..... | 15 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....                                      | 15 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....                                                                | 15 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....                                                    | 15 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....                                                                   | 16 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....                                                                                      | 16 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....                                                            | 17 |

**Товчилсон үгийн жагсаалт**

|          |                                                             |
|----------|-------------------------------------------------------------|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| ТӨБЗГ    | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар                   |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжэнцэнгийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (975) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2025.03.15 № 2190

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянхонгор аймгийн Үйлдвэржилт хөгжлийн корпорац ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өмнөх онд аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, тайлант онд 199,109.6 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү хугацаа хэтэрсэн, санхүүгийн тайлан ирүүлэхдээ эхний үлдэгдлийг зөрүүтэй илэрхийлсэн зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчил нь Жижиг дунд үйлдвэрлэл дэмжих зээлийн гэрээний 3.1.7 "Төслийн санхүүжилтийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлж барагдуулна" 5.2.5 "Төслийн санхүүжилтийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн төлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 "Үнэн зөв байх", УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, MNS-6817-

5020434

4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх болон Эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

#### **Аудитын гол асуудал**

2024 онд нийт цэвэр борлуулалт нь 244,171.6 мянга, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 380,655.4 мянган төгрөгийн зардалтай. Ерөнхий ба удирдлагын зардалд 118,511.6 мянган төгрөгийн зардалтай, үйл ажиллагааны бус зардалд орлого зардлын зөрүүгээр 62,845.9 мянган төгрөгийн олз гарч, 192,149.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилт, 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 82.7 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Б.МӨНХБАТ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код  | Балансын үзүүлэлт                                | Эхний үлдэгдэл                 | Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/    |
|-------------|--------------------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| <b>1</b>    | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                   | <b><u>1,881,939,006.82</u></b> | <b><u>1,928,001,946.89</u></b> |
| <b>31</b>   | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>                            | 75,060,736.52                  | 251,579,865.24                 |
| <b>311</b>  | <b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>                | 1,222,350.27                   | 350.27                         |
| 31110       | Төгрөг                                           | 1,222,350.27                   | 350.27                         |
| <b>312</b>  | <b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>                | 73,838,386.25                  | 251,579,514.97                 |
| <b>3121</b> | <b>Төгрөг</b>                                    | 73,838,386.25                  | 251,579,514.97                 |
| 31213       | Арилжааны банк дахь харилцах                     | 73,838,386.25                  | 251,579,514.97                 |
| <b>33</b>   | <b>АВЛАГА</b>                                    | 1,804,952,238.43               | 1,669,415,536.57               |
| 33200       | Төлбөртэй үйлчилгээний авлага                    | 19,079,851.14                  | 72,508,546.36                  |
| 33402       | Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/                  | 73,435.27                      | 28,052.00                      |
| <b>336</b>  | <b>Зээлийн авлага</b>                            | 1,785,798,952.02               | 1,596,878,938.21               |
| <b>3361</b> | <b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлаа</b> | 1,785,798,952.02               | 1,596,878,938.21               |
| 33612       | Хувь хүмүүст олгосон зээл                        | 1,785,798,952.02               | 1,596,878,938.21               |
| <b>35</b>   | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>                            | 1,926,031.87                   | 7,006,545.08                   |
| <b>354</b>  | <b>Хангамжийн материал</b>                       | 1,926,031.87                   | 7,006,545.08                   |
| 35410       | Бичиг хэргийн материал                           | 536,950.99                     | 00.00                          |
| 35420       | Аж ахуйн материал                                | 51,231.69                      | 600,181.48                     |
| 35440       | Түлш, шатах тослох материал                      | 1,337,849.19                   | 6,406,363.60                   |
| <b>2</b>    | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>               | <b><u>3,243,284,449.99</u></b> | <b><u>3,211,966,587.54</u></b> |
| <b>39</b>   | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>                            | 3,243,284,449.99               | 3,211,966,587.54               |
| <b>392</b>  | <b>Биет хөрөнгө</b>                              | 3,113,574,449.99               | 3,081,756,587.54               |
| 39201       | Барилга, байгууламж, орон сууц                   | 4,083,245,203.33               | 4,102,858,882.15               |
| 39202       | Хуримтлагдсан элэгдэл                            | 1,035,400,785.93               | -1,230,561,536.54              |
| 39205       | Машин тоног төхөөрөмж (компьютер)                | 90,328,993.94                  | 281,288,084.30                 |
| 39206       | Хуримтлагдсан элэгдэл                            | -86,883,628.99                 | -94,459,182.22                 |
| 39207       | Тавилга, аж ахуйн эд хогшил                      | 28,788,180.90                  | 34,429,090.00                  |
| 39208       | Хуримтлагдсан элэгдэл                            | -11,219,013.93                 | -19,930,625.06                 |
| 39214       | Бусад үндсэн хөрөнгө                             | 45,003,380.00                  | 9,002,776.36                   |
| 39215       | Хуримтлагдсан элэгдэл                            | -287,878.78                    | -870,901.45                    |
| <b>393</b>  | <b>Биет бус хөрөнгө</b>                          | 129,710,000.00                 | 130,210,000.00                 |
| 39301       | Програм хангамж                                  | 1,000,000.00                   | 1,000,000.00                   |
| 39302       | Хуримтлагдсан элэгдэл                            | -750,000.00                    | -1,000,000.00                  |
| 39303       | Бусад биет бус хөрөнгө                           | 129,460,000.00                 | 130,210,000.00                 |
| <b>3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>               | <b><u>5,125,223,456.81</u></b> | <b><u>5,139,968,534.43</u></b> |
| <b>4</b>    | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>                            | <b><u>2,035,548,538.26</u></b> | <b><u>2,037,819,775.70</u></b> |
| <b>41</b>   | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                 | 217,590,448.26                 | 241,480,343.7                  |
| <b>413</b>  | <b>Өглөг</b>                                     | 50,546,636.88                  | 66,710,832.32                  |
| <b>4136</b> | <b>Бусад өглөг</b>                               | 50,546,636.88                  | 66,710,832.32                  |
| 41363       | Татварын өглөг /ТӨҮГ/                            | 50,535,491.60                  | 62,332,587.17                  |

**Баянхонгор аймгийн Үйлдвэржилт хөгжлийн корпорац ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

|             |                                                                       |                          |                          |
|-------------|-----------------------------------------------------------------------|--------------------------|--------------------------|
| 41366       | Дансны өглөг /ТӨҮГ/                                                   | 11,145.28                | 4,379,245.15             |
| <b>414</b>  | <b>Урьдчилж орсон орлого</b>                                          | 167,043,811.38           | 174,769,511.38           |
| 41440       | Бусад урьдчилж орсон орлого                                           | 167,043,811.38           | 174,769,511.38           |
| <b>42</b>   | <b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                         | 1,817,958,090.00         | 1,796,339,432.00         |
| <b>422</b>  | <b>Урт хугацаат зээл</b>                                              | 1,817,958,090.00         | 1,796,339,432.00         |
| <b>4221</b> | <b>Төгрөг</b>                                                         | 1,817,958,090.00         | 1,796,339,432.00         |
| 42212       | Хувь хүмүүсийн зээл                                                   | 1,817,958,090.00         | 1,796,339,432.00         |
| <b>5</b>    | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>3,089,674,918.55</b>  | <b>3,102,148,758.73</b>  |
| <b>51</b>   | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | <b>3,089,674,918.55</b>  | <b>3,102,148,758.73</b>  |
| 511         | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 4,350,686,922.36         | 4,350,687,732.10         |
| 5110002     | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө                                 | 4,350,686,922.36         | 4,350,687,732.10         |
| <b>512</b>  | <b>Хуримтлагдсан үр дүн</b>                                           | <b>-1,261,012,003.81</b> | <b>-1,248,538,973.37</b> |
| 51210       | Өмнөх үеийн үр дүн                                                    | -1,032,322,709.35        | -1,261,012,003.81        |
| 51220       | Тайлант үеийн үр дүн                                                  | -228,689,294.46          | 12,473,030.44            |
| <b>6</b>    | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b>5,125,223,456.81</b>  | <b>5,139,968,534.43</b>  |

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**

| Дансны код  | Үзүүлэлт                                         | Өмнөх оны гүйцэтгэл    | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--------------------------------------------------|------------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>           | <b>230,903,212.24</b>  | <b>511,640,077.52</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                       | <b>230,903,212.24</b>  | <b>511,640,077.52</b> |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого                 | 230,903,212.24         | 511,640,077.52        |
| 1200041     | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих        | 199,915,311.34         | 244,171,628.22        |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих        | 30,987,900.90          | 62,845,952.30         |
| 120017      | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 0.0                    | 204,622,497.00        |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>               | <b>458,894,118.29</b>  | <b>499,167,047.08</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                             | <b>458,894,118.29</b>  | <b>499,167,047.08</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>           | 458,894,118.29         | 499,167,047.08        |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>           | 458,894,118.29         | 499,167,047.08        |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                  | 240,965,132.16         | 287,136,109.51        |
| 210903      | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол               | 217,928,986.13         | 212,030,937.57        |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>        | <b>-227,990,906.05</b> | <b>12,473,029.94</b>  |
| <b>225</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>           | 698,388.41             | 00.00                 |
| 225001      | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз                   | 698,388.41             | 00.00                 |
| <b>4</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>  | -228,689,294.46        | 12,473,030.44         |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Баянхонгор аймгийн Үйлдвэржилт хөгжлийн корпорац ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

| Дансны код  | Үзүүлэлт                                                                   | Өмнөх оны гүйцэтгэл          | Тайлант оны гүйцэтгэл        |
|-------------|----------------------------------------------------------------------------|------------------------------|------------------------------|
|             | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                                      |                              |                              |
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>                              | <b><u>797,973,276.31</u></b> | <b><u>737,597,779.29</u></b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                                                 | <b><u>797,973,276.31</u></b> | <b><u>737,597,779.29</u></b> |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                                         | <b><u>797,973,276.31</u></b> | <b><u>737,597,779.29</u></b> |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого                                           | <u>797,973,276.31</u>        | <u>737,597,779.29</u>        |
| 1200041     | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                                  | 251,308,502.32               | 305,046,150.47               |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                                  | 546,664,773.99               | 432,551,628.82               |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>                               | <b><u>844,143,598.49</u></b> | <b><u>542,757,632.38</u></b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                       | <b><u>844,143,598.49</u></b> | <b><u>542,757,632.38</u></b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                     | <b><u>844,143,598.49</u></b> | <b><u>542,757,632.38</u></b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                                   | 92,041,317.00                | 125,355,267.43               |
| 210101      | Үндсэн цалин                                                               | 92,041,317.00                | 125,355,267.43               |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                      | 26,374,763.01                | 19,110,315.42                |
| 210201      | Тэтгэврийн даатгал                                                         | 26,374,763.01                | 19,110,315.42                |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                     | 725,727,518.48               | 417,402,364.95               |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                            | 725,727,518.48               | 417,402,364.95               |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>                    | <b><u>-46,170,322.18</u></b> | <b><u>194,840,146.91</u></b> |
| <b>5</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>                           | <b><u>7,909,090.90</u></b>   | <b><u>18,321,018.19</u></b>  |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                                    | <b><u>7,909,090.90</u></b>   | <b><u>18,321,018.19</u></b>  |
| <b>2200</b> | <b>Дотоод эх үүсвэрээр</b>                                                 | <b><u>7,909,090.90</u></b>   | <b><u>18,321,018.19</u></b>  |
| 225106      | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                             | 7,909,090.90                 | 18,321,018.19                |
| <b>6</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b> | <b><u>-7,909,090.90</u></b>  | <b><u>-18,321,018.19</u></b> |
| <b>8</b>    | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                           | -54,079,413.08               | 176,519,128.72               |
| <b>9</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                    | 129,140,149.60               | 75,060,736.52                |
| <b>10</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>                   | 75,060,736.52                | 251,579,865.24               |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт                                | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн        | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|-----------------------------------------|---------------------------------|--------------------------|-----------------------------------------|
| C01 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл   | 4,332,186,922.36                | -1,032,322,709.35        | 3,299,864,213.01                        |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл              | <b>4,332,186,922.36</b>         | <b>-1,032,322,709.35</b> | 3,299,864,213.01                        |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | <b>18,500,000.00</b>            | 00.00                    | 18,500,000.00                           |

**Баянхонгор аймгийн Үйлдвэржилт хөгжлийн корпорац ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

|     |                                              |                         |                          |                  |
|-----|----------------------------------------------|-------------------------|--------------------------|------------------|
| C07 | Тайлант үеийн үр дүн                         | 00.00                   | -228,689,294.46          | -228,689,294.46  |
| D01 | <b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b> | <b>4,350,686,922.36</b> | <b>-1,261,012,003.81</b> | 3,089,674,918.55 |
| D03 | <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>            | <b>4,350,686,922.36</b> | <b>-1,261,012,003.81</b> | 3,089,674,918.55 |
| D07 | Өмчид гарсан өөрчлөлт                        | 74,363,497.00           | 00.00                    | 74,363,497.00    |
| D08 | Тайлант үеийн үр дүн                         | 00.00                   | -192,148,656.82          | -192,148,656.82  |
| D09 | <b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b> | <b>4,425,050,419.34</b> | <b>-1,453,160,660.63</b> | 2,971,889,758.73 |

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний тайлан**

|                         |                                     | /төгрөгөөр/               |                       |                        |                |       |
|-------------------------|-------------------------------------|---------------------------|-----------------------|------------------------|----------------|-------|
| д/д                     | Үзүүлэлт                            | 2024 оны төлөвлөгөө       | 2024 оны гүйцэтгэл    | Зөрүү                  | Хувь           |       |
| 1                       | Зээлийн эргэн төлөлтийн төлөвлөлт   | 600,000,000.00            | 454,117,691.00        | 145,882,309.00         | 75.7           |       |
| 2                       | Төсөл хөтөлбөр                      | 1,800,000.00              | 1,025,000.00          | 775,000.00             | 56.9           |       |
| 3                       | Түрээсийн орлого                    | Ажилсаг төв               | 162,781,300.00        | 159,205,359.00         | 3,575,941.00   | 97.8  |
|                         |                                     | Ахуй үйлчилгээ            | 103,687,900.00        | 110,141,300.00         | (6,453,400.00) | 106.2 |
|                         |                                     | Хөнгөлөлт                 | -                     | -                      | -              |       |
| 4                       | Тоног төхөөрөмжийн хяналт           | -                         | -                     | -                      |                |       |
| 5                       | Санхүүжилт                          | 50,000,000.00             | 50,000,000.00         | -                      | 100.0          |       |
| 6                       | Кителийн сургалтын санхүүжилт       |                           | 11,700,000.00         | (11,700,000.00)        |                |       |
| 7                       | Бусад орлого/ ажилсаг төв цахилгаан |                           | 32,125,072.80         | (32,125,072.80)        |                |       |
| <b>Нийт орлогын дүн</b> |                                     | <b>266,469,200.00</b>     | <b>332,071,659.00</b> | <b>(65,602,459.00)</b> | <b>124.6</b>   |       |
| 1-6                     | Цалин урамшуулал                    | Цалин                     | 152,040,000.00        | 142,945,071.00         | 9,094,929.00   | 94.0  |
|                         |                                     | Үр дүн урамшуулал         | 5,020,000.00          | 3,444,400.00           | 1,575,600.00   | 68.6  |
|                         |                                     | ЭМД, НДШ                  | 19,632,500.00         | 16,078,165.77          | 3,554,334.23   | 81.9  |
|                         |                                     | Албан томилолт            | 2,560,000.00          | 2,500,000.00           | 60,000.00      | 97.7  |
|                         |                                     | Элэгдлийн зардал          | 233,609,580.89        | 212,028,537.64         | 21,581,043.25  | 90.8  |
|                         |                                     | Тэтгэмж шагнал урамшуулал | 2,100,000.00          | 1,480,000.00           | 620,000.00     | 70.5  |
| 7-9                     | ТУЗ                                 | ТУЗ урамшуулал            | 6,800,000.00          | 3,000,000.00           | 3,800,000.00   | 44.1  |
|                         |                                     | ТУЗ бусад зардал          | 500,000.00            | 44,230.00              | 455,770.00     | 8.8   |
|                         |                                     | ТУЗ бичиг хэргийн зардал  | 40,000.00             | -                      | 40,000.00      | -     |

**Баянхонгор аймгийн Үйлдвэржилт хөгжлийн корпорац ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

| д/д | Үзүүлэлт           | 2024 оны төлөвлөгөө                   | 2024 оны гүйцэтгэл | Зөрүү         | Хувь            |       |
|-----|--------------------|---------------------------------------|--------------------|---------------|-----------------|-------|
| 10  | Ашиглалтын зардал  | Цахилгааны зардал                     | 38,978,638.80      | 25,573,536.23 | 13,405,102.57   | 65.6  |
| 11  |                    | Нүүрсний зардал                       | 7,000,000.00       | 6,248,975.00  | 751,025.00      | 89.3  |
| 12  |                    | Тээврийн зардал                       | 9,450,000.00       | 2,671,400.00  | 6,778,600.00    | 28.3  |
| 13  |                    | Халаалтын зардал                      | 39,679,860.00      | 45,573,924.75 | (5,894,064.75)  | 114.9 |
| 14  |                    | Хог тээврийн зардал                   | 1,680,000.00       | 900,000.00    | 780,000.00      | 53.6  |
| 15  |                    | Цэвэр бохир усны зардал               | 3,253,536.00       | 4,656,740.00  | (1,403,204.00)  | 143.1 |
| 16  |                    | Шуудан холбооны зардал                | 1,340,000.00       | 1,778,468.00  | (438,468.00)    | 132.7 |
| 17  |                    | Бичиг хэргийн зардал                  | 4,378,000.00       | 3,316,100.00  | 1,061,900.00    | 75.7  |
| 18  | Бусад зардал       | Шатахууны зардал                      | 6,000,000.00       | 4,366,429.00  | 1,633,571.00    | 72.8  |
| 19  |                    | Хангамжийн материалын зардал захиргаа | 1,240,000.00       | 1,428,836.00  | (188,836.00)    | 115.2 |
| 20  |                    | Ариутгал цэвэрлэгээ                   | 4,431,600.00       | 4,183,810.00  | 247,790.00      | 94.4  |
| 21  |                    | БГАҮ зардал                           | 2,000,000.00       | 3,422,900.00  | (1,422,900.00)  | 171.1 |
| 22  |                    | Бусад зардал /дотоод ажил/            | 5,040,000.00       | 3,967,700.00  | 1,072,300.00    | 78.7  |
| 23  |                    | Зар сурталчилгаа                      | 500,000.00         | 198,000.00    | 302,000.00      | 39.6  |
| 24  |                    | Кителийн Сургалтын зардал             | -                  | 10,060,000.00 | (10,060,000.00) |       |
| 25  |                    | Сургалт                               | 1,950,000.00       |               | 1,950,000.00    | -     |
| 26  | Татвар хураамж     | Газрын төлбөр                         | 500,000.00         | 444,000.00    | 56,000.00       | 88.8  |
| 27  |                    | Татвар                                | 30,000,000.00      | 22,422,875.21 | 7,577,124.79    | 74.7  |
| 28  | Хөрөнгө оруулалт   | Засвар үйлчилгээний зардал            | 13,050,000.00      | 25,624,000.00 | (12,574,000.00) | 196.4 |
| 29  |                    | Урсгал засвар                         | 21,780,000.00      | 21,895,000.00 | (115,000.00)    | 100.5 |
| 30  |                    | Сэлбэгийн зардал                      | 3,000,000.00       | 634,818.18    | 2,365,181.82    | 21.2  |
| 31  | Хөдөлмөр хамгаалал | Гамшгийн нөөцийн зардал               | 2,055,500.00       | -             | 2,055,500.00    | -     |
| 32  |                    | Хөдөлмөр хамгаалал                    | 3,889,000.00       | 3,481,198.00  | 407,802.00      | 89.5  |
| 33  | БТ-ын зардал       | Бодлого төлөвлөлтийн Хяналтын зардал  | 10,000,000.00      | 3,055,400.00  | 6,944,600.00    | 30.6  |

|    |                                        |                         |                         |                  |         |
|----|----------------------------------------|-------------------------|-------------------------|------------------|---------|
| 34 | Бодлого төлөвлөлтийн бусад зардал      | 5,200,000.00            | 567,118.56              | 4,632,881.44     | 10.9    |
| 35 | Бодлого төлөвлөлтийн томилолтын зардал | 2,544,000.00            | 2,500,000.00            | 44,000.00        | 98.3    |
|    | Үйл ажиллагааны дүн                    | <b>641,242,215.69</b>   | <b>580,491,633.34</b>   | 60,750,582.35    | 90.5    |
|    | Үйл ажиллагааны ашиг алдагдал          | <b>(374,773,015.69)</b> | <b>(248,419,974.34)</b> | (126,353,041.35) | 66.3    |
|    | Үйл ажиллагааны бус орлого             | 1,000,000.00            | 32,125,072.80           | (31,125,072.80)  | 3,212.5 |
|    | Үйл ажиллагааны бус зарлага            | 2,000,000.00            | 32,125,072.80           | (30,125,072.80)  | 1,606.3 |
|    | Үйл ажиллагааны бус ашиг               | (1,000,000.00)          | -                       | (1,000,000.00)   | -       |
|    | <b>Нийт зардлын дүн</b>                | <b>643,242,215.69</b>   | <b>612,616,706.14</b>   | 30,625,509.55    | 95.2    |
|    | <b>Нийт орлогын дүн</b>                | <b>267,469,200.00</b>   | <b>364,196,731.80</b>   | (96,727,531.80)  | 136.2   |
|    | <b>Нийт ашиг алдагдал</b>              | <b>(375,773,015.69)</b> | <b>(248,419,974.34)</b> | (127,353,041.35) | 66.1    |
|    | <b>4.3 ашгийн тооцоо</b>               |                         |                         |                  |         |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Үйлдвэржилт хөгжлийн корпорац ХХК нь аймгийнхаа эдийн засгийн хөгжлийн стратеги бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, бизнесийн орчныг дэмжих замаар зах зээлийг өргөжүүлэн, ажлын байрыг нэмэгдүүлэх эрхэм зорилгынхоо дор дараах чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг сургах, хөгжүүлэх, чиглүүлэх, холбон зуучлах
- Ажлын байрны түрээсийн үйл ажиллагаа
- Төслийн зээлээр жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх
- Удирдлага арга зүйгээр хангах зэрэг байна.

#### 3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг бөгөөд санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Үйлдвэржилт хөгжлийн корпорац нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын нягтлан бодогчоор ажиллаж байсан Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогч В.Наранцэцэг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу боловсруулж, компанийн захирлын 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 05 дугаар тушаалаар баталснаар одоог хүртэл үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Үйлдвэржилт хөгжлийн корпорацын 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.3-д "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 5,139,968.5 мянган төгрөг болж өмнөх оноос 14,745.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Балансын үзүүлэлт                  | /мянган төгрөгөөр/ |                 |              |
|------------------------------------|--------------------|-----------------|--------------|
|                                    | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл | Зөрүү        |
| <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>     | 1,881,939.00       | 1,928,001.94    | 46,062.94    |
| <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>              | 75,060.70          | 251,579.86      | 176,519.16   |
| <b>АВЛАГА</b>                      | 1,804,952.20       | 1,669,415.50    | (135,536.70) |
| <b>БАРАА МАТЕРИАЛ</b>              | 1,926.00           | 7,006.50        | 5,080.50     |
| <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b> | 3,243,284.40       | 3,211,966.50    | (31,317.90)  |
| <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>              | 3,243,284.40       | 3,211,966.50    | (31,317.90)  |
| Хуримтлагдсан элэгдэл              | (1,134,541.30)     | (1,346,822.20)  | (212,280.90) |
| <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b> | 5,125,223.40       | 5,139,968.54    | 14,745.14    |

|                                                    |              |              |              |
|----------------------------------------------------|--------------|--------------|--------------|
| <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>                              | 2,035,548.50 | 2,037,819.77 | 132,530.2    |
| <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                    | 3,089,674.90 | 3,102,147.94 | (117,785.2)  |
| Засгийн газрын хувь оролцоо                        | 3,089,674.90 | 3,102,147.94 | 3,102,147.94 |
| <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b> | 5,125,223.40 | 5,139,968.53 | 14,745.13    |

Тайлант оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан данс нь мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 251,579.8 мянга болж өмнөх оноос 176,519.1 мянгаар өссөн нь хөнгөлөлттэй зээлийн зээлийн эргэн төлөлтийн орлого 454,117.6 мянган төгрөг голлох нөлөөг үзүүлжээ.

Тайлант онд авлагын данс 135,536.7 мянган төгрөгөөр буурсан нь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэдэд олгосон зээлийн авлага буурсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Тайлант оны авлагын үзүүлэлт

| Үзүүлэлт                      | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|-------------------------------|--------------------|--------------------|------------------------|-----------------|
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 19,079.8           | 72,508.5           | 53,428.6               | 4.3             |
| Дансны авлага /ТӨҮГ/          | 73.4               | 28.0               | -45.3                  | 0.0             |
| Хувь хүмүүст олгосон зээл     | 1,785,798.9        | 1,596,878.9        | -188,920.0             | 95.7            |
| <b>НИЙТ ДҮН</b>               | <b>1,804,952.2</b> | <b>1,669,415.5</b> | <b>-135,536.7</b>      | <b>100.00</b>   |

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,211,966.5 мянга болж өмнөх оноос 31,317.9 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн ИТХ-ын даргын 2024 оны “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 04 дугаар захирамжаар 1,820.0 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн Түүх угсаатны музейд, 100 дугаар захирамжаар 40,160.4 мянган төгрөгийн хөрөнгийг Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газарт шилжүүлсэн, ашиглах боломжгүй болсон 1,820.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг акталж данснаас хассан бол төсвийн хөрөнгөөр 2,291.1 мянган төгрөгийн барилгын сайжруулалт, 3,659.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 5640.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 6,729.8 мянган төгрөгийн биет бус хөрөнгө худалдан авсан, аймгийн Засаг даргын 25 дугаар захирамжаар Кеттель, нэхмэлийн үйлдвэрт 187,300.0 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, 99 дугаар захирамжийн дагуу Ажилсаг төвд 17,655.4 мянган төгрөгийн барилгын засвар хийж дахин капиталжуулж, хөрөнгөд бүртгэсэн байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Баянхонгор аймгийн Үйлдвэржилт хөгжлийн корпорацын төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01 дугаартай тогтоолоор 2024 оны бизнес төлөвлөгөөнд нийт зардлыг 644,642.2 мянган төгрөгөөр, нийт борлуулалтын орлогыг 267,469.2 мянган төгрөгөөр тооцон тайлант оны алдагдал 377,173.0 мянган төгрөг байхаар баталсан байна.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тус байгууллагад худалдан авах ажиллагаа байхгүй.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Үйлдвэржилт хөгжлийн корпорац ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Адилзаяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Үйлдвэржилт хөгжлийн корпорац ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны бизнес төлөвлөгөөний нийт зардлын дүн болох 644,642.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,669.6 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 6,285.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан орлогын 38,925.2 мянган төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын 61,778.9 мянган төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь “6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8-д заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

##### **4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж аудитаар нийт 138,557.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгснийг биелүүлсэн талаар тус байгууллагаас FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт*, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                  | Биелэлт  |                  |               |
|-----------------|------------------------|------------------|----------|------------------|---------------|
|                 | Тоо                    | Дүн              | Тоо      | Дүн              | Хувь          |
| Албан шаардлага | 1                      | 138,557.0        | 1        | 120,161.2        | 86.72%        |
| <b>Нийт дүн</b> | <b>1</b>               | <b>138,557.0</b> | <b>1</b> | <b>120,161.2</b> | <b>86.72%</b> |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал Байхгүй

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**5.1** Аудитаар нийт 900.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

5.1.1 Санхүү байдлын тайлангийн эхний үлдэгдлийг 900.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.2 “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” заалтын дагуу залруулав.

**5.2** Аудитаар нийт 299,813.7 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>2</sup> илэрснээс 199,109.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 100,704.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлэв.

#### 5.2.1 Төлбөрийн акт

5.2.1.1 Хөнгөлөлттэй зээл авсан нийт 43 иргэний 199,109.6 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү хугацаа хэтэрсэн байна.

Энэ нь Жижиг дунд үйлдвэрлэл дэмжих зээлийн гэрээний 3.1.7 “Төслийн санхүүжилтийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлж барагдуулна” 5.2.5 “Төслийн санхүүжилтийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн төлөх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүг төлүүлэх, барагдаагүй тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлж, зөрчлийг арилгах төлбөрийн акт тогтоов.

#### 5.2.2 Албан шаардлага

5.2.2.1 Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 саяас дээш орлогын 38,925.2 мянган төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын 61,778.9 мянган төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансанд нөхөж мэдээлэх, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2.2 Өмнөх оны аудитаар илэрсэн 138,557.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүг санд бүрэн төвлөрүүлэх, насжилт үүсэж буй зээлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх албан шаардлагын хэрэгжилт 86.72 хувьтай буюу 18,395.7 мянган төгрөгийн зээлийг төлүүлэх арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Жижиг дунд үйлдвэрлэл дэмжих зээлийн гэрээний 3.1.7 “Төслийн санхүүжилтийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлж барагдуулна” 5.2.5 “Төслийн санхүүжилтийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн төлөх”, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйл 70.1 “Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамжийг гарсан өдрөөс нь эхлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар биелүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хугацаа хэтэрсэн зээлийн шүүхийн шийдвэрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлж, холбогдох арга хэмжээг авах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга                                                                                                                                                                                                                                                                                         | Нийт алдаа |              | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |              | Буруу тусган илэрхийлсэн |     | Үүнээс     |              |              |     | Зөвлөмж |     |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|--------------|-----------------------------------|--------------|--------------------------|-----|------------|--------------|--------------|-----|---------|-----|
|                                                                                                                                                                                                                                                                                                           | Тоо        | Дүн          | Тоо                               | Дүн          | Тоо                      | Дүн | Залруулсан |              | Залруулаагүй |     | Тоо     | Дүн |
|                                                                                                                                                                                                                                                                                                           |            |              |                                   |              |                          |     | Тоо        | Дүн          | Тоо          | Дүн |         |     |
| Санхүү байдлын тайлангийн эхний үлдэгдлийг 900.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 “Үнэн зөв, 15 дугаар зүйл 15.2 “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” заалтыг зөрчсөн байна. | 1          | 900.0        | 1                                 | 900.0        |                          |     | 1          | 900.0        |              |     |         |     |
| <b>Дүн</b>                                                                                                                                                                                                                                                                                                | <b>1</b>   | <b>900.0</b> | <b>1</b>                          | <b>900.0</b> |                          |     | <b>1</b>   | <b>900.0</b> |              |     |         |     |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Баянхонгор аймгийн Үйлдвэржилт хөгжлийн корпорац ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

| Зөрчлийн товч утга                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | Нийт зөрчил |                   | Үүнээс        |                   |                 |                   |         |     |                                      |                     |                                                 |     |  |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-------------------|---------------|-------------------|-----------------|-------------------|---------|-----|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|-----|--|
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |             |                   | Төлбөрийн акт |                   | Албан шаардлага |                   | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |  |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | Тоо         | Дүн               | Тоо           | Дүн               | Тоо             | Дүн               | Тоо     | Дүн | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо                                             | Дүн |  |
| Хөнгөлөлттэй зээл авсан нийт 43 иргэний 199,109.6 мянган төгрөгийн зээл,зээлийн хүү хугацаа хэтэрсэн байгаа нь Жижиг дунд үйлдвэрлэл дэмжих зээлийн гэрээний 3.1.7 5.2.5 дахь заалтуудыг зөрчсөн байна                                                                                                                                                                                                                                                                                  | 1           | 199,109.60        | 1             | 199,109.60        |                 |                   |         |     |                                      |                     |                                                 |     |  |
| Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 саяас дээш орлогын 38,925.2 мянган төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын 61,778.9 мянган төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудыг зөрчсөн байна.                                                                                                                                                                                               | 1           | 100,704.1         |               |                   | 1               | 100,704.10        |         |     |                                      |                     |                                                 |     |  |
| Өмнөх оны аудитаар илэрсэн 138,557.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүг санд бүрэн төвлөрүүлэх, насжилт үүсэж буй зээлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх албан шаардлагын хэрэгжилт 86.72 хувьтай буюу 18,395.7 мянган төгрөгийн зээлийг төлүүлэх арга хэмжээ аваагүй байгаа нь Жижиг дунд үйлдвэрлэл дэмжих зээлийн гэрээний 3.1.7 5.2.5, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйл 70.1 дэх заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | 1           | 18,395.70         |               |                   | 1               | 18,395.70         |         |     |                                      |                     |                                                 |     |  |
| <b>Дүн</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | <b>3</b>    | <b>217,505.30</b> | <b>1</b>      | <b>199,109.60</b> | <b>2</b>        | <b>119,099.80</b> |         |     |                                      |                     |                                                 |     |  |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----